



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/86 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн өмчөөс шилжүүлсэн Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын нийт 1,537,122,705.10 (нэг тэрбум таван зуун гучин долоон сая нэг зуун хорин хоёр мянга долоон зуун таван төгрөг арван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 516,497,360.13 (таван зуун арван зургаан сая дөрвөн зуун ерэн долоон мянга гурван зуун жаран төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Ц.Мөнхбаяр, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Улаанхүү нарт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Увс аймгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Холбогдох журам, зааврын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах (Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газар);

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000683

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 сарын 29-ний өдрийн
35.7 дугаар тогтоолын хавсралт

УВС АЙМГИЙН МЭРТЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭД ХӨРӨНГИЙН ХУРААНГУЙ ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн төрөл (дансны ангиллаар)	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Нийт үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Барилга, байгууламж	6	768,983,101.00	9,821,900.68	759,161,200.32
2	Нийтийн эзэмшлийн байгууламж	4	17,402,626.00	10,702,271.14	6,700,354.86
2	Машин тоног төхөөрөмж	306	576,519,291.46	365,663,067.79	210,856,223.67
3	Тээврийн хэрэгсэл	2	85,716,100.00	81,183,967.38	4,532,132.62
4	Тавилга эд хогшил	457	61,246,716.64	47,771,283.14	13,475,433.50
5	Биет бус хөрөнгө	3	27,254,870.00	1,354,870.00	25,900,000.00
	Дүн	778	1,537,122,705.10	516,497,360.13	1,020,625,344.97
			(нэг тэрбум таван зуун гучин долоон сая нэг зуун хорин хоёр мянга долоон зуун таван төгрөг арван мөнгө)	(таван зуун арван зургаан сая дөрвөн зуун ерэн долоон мянга гурван зуун жаран төгрөг арван гурван мөнгө)	(нэг тэрбум хорин сая зургаан зуун хорин таван мянга гурван зуун дөрвөн төгрөг ерэн долоон мөнгө)